

189
185

НЗД-дэс 1993 дээр А282-р залуулж
хүчинчлэх

БИМАУ-ЫН ТЭЭВРИЙН ЯМ, УЛААНБААТАР
ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ХАМТАРСАН ТОГТООЛ

1988.XI.30

Дугаар 293/324 Улаанбаатар хот

Улаанбаатар хотын зорчигч тээврийн комбинат байгуулах тухай

Удирдлагын бутцийг соловсронгуй болгох, зардал хямдруулах, шат дамиллагыг багасгах, зорчигч тээврийн үйлчилгээг диспетчерийн нэгдсэн удирдлагаар хангах, кондукторгүй үйлчилгээг нэвтрүүлэх зорилгоор БИМАУ-ЫН ТЭЭВРИЙН ЯМ, Улаанбаатар хотын АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНААС ТОГТООХ нь:

Нэг. Автобусны комбинат, Троллейбусны комбинатыг нэгтгэн, дотоод аж ахуйн тооц rootой, бие даасан баланстай троллейбусны аж ахуй, цахилгаан хангамжийн алба, автобусны ашиглалтын I, II парк, засвар техникийн үйлчилгээний станц, хяналт, борлуулалтын контор зэрэг үндсэн нэгжтэйгээр Улаанбаатар хотын зорчигч тээврийн комбинатыг байгуулж, 1989 оны I дугаар сарын I-нээс эхлэн туршилтын журмаар ажиллуулсугай.

Хоёр. Зорчигч тээврийн комбинатын 1989 онд мөрдөх ажиллах цалингийн нормативыг 26.90 мянгөөр баталж, тооцоонны үнийн түвшинг тээвэр, санхүүгийн төлөвлөгөөний үндсэн дээр тогтоож мөрдүүлэхийг Санхүү, тайлан бүртгэлийн хэлтэс /н. Монхор/-т даалгасугай.

Гурав. Улаанбаатар хотын зорчигч тээврийн комбинатын захиргаанд даалгах нь:

а/ Тус хоёр комбинатын захиргаа, боловсон хүчин, төлөвлөгөө, санхүү, билет борлуулалт, диспетчер, хяналт шалгалт, техник хангамжийн албыг нэгтгэж, одоогийн орон тоо, цалингийн фондыг хэмнэх чиглэлээр мөрдөгдөх байгаа албан тушаалын цалинг баримжаа болгон удирдлагын зохион байгуулалт, бутцээ батлан мөрдсүгэй;

б/ Хяналт, борлуулалтын конторыг 1988 онд багтаан байгуулж, билет борлуулах, зорчигчийн хэлс төлөлтэнд тавих хяналтыг улам эрчимжүүлэн ажилласугай.

185
186

2.


в/Зорчигч тээврийн комбинат, түүний аж ахуйн дотоод тооцоотой, бие даасан баланстай үндсэн нэгж, байгууллагын тэмдэг, нүүр гаргал тус тусын хуучин тэмдэг, нүүрийг тур хэрэглэж байсугай.

Дөрөв. Улаанбаатар хотын зорчигч тээврийн комбинат, түүний дотоод аж ахуйн тооцоотой, бие даасан баланстай нэгж байгууллагуудын тэмдэг, нүүрийг 1989 оны нэгдүгээр сард багтаан хийлгэхийг Тээврийн яамны боловсон хүчин, захирагааны газар /н.Энхболд/-т даалгасугай.

Тав. Зорчин явалтын хөлс төлөлтийг шалгах ажилд байнгын туслалцаа узуулж, билет борлуулах цэгүүдийг хяналт хамгаалалтандaa авч ажиллахыг Улаанбаатар хотын цагдан сэргийлэх газар /н.Хүрүүгээрэл/-т даалгасугай.



БНМАУ-ЫН ТЭЭВРИЙН ЯАМНЫ
СААН
Д. ЕНДОНСҮРЭН



УЛААНБААТАР АЛХ-ЫН
ГҮҮЛЭГТЭХ ЗАХИРТААНЫ
ДАРГА
С. МӨНХЖАРГАЛ